



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/535

Зуунмод

Зардал гаргах тухай

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1, 3.2-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахлыг илрүүлэх шинжилгээний түргэвчилсэн оношлуур худалдан авахад зориулан 27.500.000 (хорин долоон сая таван зуун мянган) төгрөгийн зардал гаргасугай.
2. Зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг Засаг даргын Тамгын газар (С.Магнайбаяр) нарт зөвшөөрсүгэй.
3. Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа)-т үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4121011343